

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Соёлын төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/141/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelqerb@audit.gov.mn](mailto:tegshdelqerb@audit.gov.mn)

Аудитор: Л.Мандахнаран  
Утас: 99389927 Цахим хаяг: [MandakhnaranL@audit.gov.mn](mailto:MandakhnaranL@audit.gov.mn)

Гурван Хөх Морьт Аудит ХХК  
Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг  
Утас: 99051815 Цахим хаяг: [gurvankhukhmoritllc@gmail.com](mailto:gurvankhukhmoritllc@gmail.com)  
Аудитор: Д.Соёлсайхан  
Утас: 91929196 Цахим хаяг: [gurvankhukhmoritllc@gmail.com](mailto:gurvankhukhmoritllc@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-ҮҮР  
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА  
Л.АЛТАНХУЯГ ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/270  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Соёлын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Мөнгөн хөрөнгө данс өмнөх оноос 2,131.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлдэггүй байсан бол тайланд онд зарцуулаагүй үлдсэн төсвийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой бууралт байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 32,552.5 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс 972.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 31,580.0 мянган төгрөгийн зөрчилд 7 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Соёлын төвийн дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

#### Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

670021018

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,379,284.5</b>	<b>26,402,300.0</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	2,131,796.5	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	2,131,796.5	-
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	2,131,796.5	-
31211	Төрийн сангийн харилцах	2,131,796.5	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	22,247,488.0	26,402,300.0
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	13,442,688.0	16,090,000.0
35110	Тусгай зориулалттай материал	13,442,688.0	16,090,000.0
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	8,804,800.0	10,312,300.0
35410	Бичиг хэргийн материал	234,600.0	310,600.0
35420	Аж ахуйн материал	165,600.0	610,600.0
35440	Түлш, шатах тослох материал	5,463,500.0	8,250,000.0
35470	Бусад хангамжийн материал	2,941,100.0	1,141,100.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>317,872,419.2</b>	<b>368,060,730.2</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	317,872,419.2	368,060,730.2
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	304,656,919.2	355,116,896.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	270,543,240.3	270,543,240.3
39202	Хуримтлагдсан элэгдэл	(31,575,646.2)	(36,838,253.9)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	29,800,000.0
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	64,294,496.0	103,461,566.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(18,107,942.1)	(31,366,762.6)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,084,654.5	18,204,654.5
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,468,392.3)	(13,319,856.4)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,660,480.0	3,660,480.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,525,200.0)	(1,779,400.0)
39217	Ном	11,751,229.0	12,751,229.0
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13,215,500.0	12,943,833.3
39301	Програм хангамж	1,630,000.0	1,630,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(408,500.0)	(680,166.7)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,994,000.0	11,994,000.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>342,251,703.7</b>	<b>394,463,030.2</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>110,711.0</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	110,711.0
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	110,711.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	110,711.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>342,251,703.7</b>	<b>394,352,319.2</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	342,251,703.7	394,352,319.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	385,738,624.5	385,738,624.5
51101	Өмч: - төрийн	385,738,624.5	385,738,624.5
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(44,211,280.8)	7,889,334.7
51210	Өмнөх үеийн үр дүн	(72,980,166.6)	(44,211,280.8)
51220	Тайлант үеийн үр дүн	28,768,885.8	52,100,615.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	724,360.0	724,360.0
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>342,251,703.7</b>	<b>394,463,030.2</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>221,857,777.7</b>	<b>369,309,486.9</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>49,123,037.5</b>	<b>73,059,670.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	49,123,037.5	73,059,670.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,123,037.5	73,059,670.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,322,600.0	12,759,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.0	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	42,200,437.5	60,300,670.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>172,734,740.2</b>	<b>296,249,816.9</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	152,171,287.0	271,439,816.9
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	152,171,287.0	271,439,816.9
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	20,585,700.0	24,810,000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,585,700.0	24,810,000.0
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	(22,246.8)	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	(22,246.8)	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>184,774,891.9</b>	<b>317,208,871.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>184,774,891.9</b>	<b>317,208,871.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	164,070,691.9	263,110,465.9
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	106,576,504.5	173,539,344.0
210101	Үндсэн цалин	75,553,170.5	106,397,300.0
210102	Нэмэгдэл	24,181,658.0	51,892,472.0
210104	Урамшуулал	6,841,676.0	15,249,572.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	12,257,097.0	20,987,233.0
210201	Тэтгэврийн даатгал	8,026,797.0	14,264,692.7
210202	Тэтгэмжийн даатгал	1,057,500.0	1,727,362.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	845,900.0	863,681.2
210204	Ажилгүйдлийн даатгал	211,600.0	821,843.7
210205	Эрүүл мэндийн даатгал	2,115,300.0	3,309,653.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,140,359.2	15,045,515.9
210301	Гэрэл, цахилгаан	1,977,753.2	3,132,015.9
210302	Түлш, халаалт	11,112,606.0	11,613,500.0
210303	Цэвэр, бохир ус	50,000.0	300,000.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,098,069.0	8,067,688.0
210401	Бичиг хэрэг	1,840,600.0	2,324,000.0
210402	Тээвэр, шатахуун	799,969.0	1,800,005.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	550,000.0	660,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	999,995.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,907,500.0	879,000.0
210408	Бараа материал акталсны зардал	-	1,404,688.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,535,700.0	4,030,000.0
210604	Урсгал засвар	4,535,700.0	4,030,000.0
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	200,000.0	1,300,000.0
210702	Дотоод албан томилот	200,000.0	1,300,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,647,338.0	17,171,926.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,311,356.0	14,369,100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	864,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.0	1,900,000.0
210807	Газрын төлбөр	155,982.0	38,826.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,615,624.2	22,968,759.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.0	3,070,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,015,624.2	19,898,759.0

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,704,200.0	54,098,405.5
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,704,200.0	15,094,300.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,552,800.0	1,539,900.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	11,974,400.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,151,400.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	1,580,000.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	36,526,121.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	36,526,121.3
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	2,477,984.1
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,477,984.1
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>37,082,885.8</b>	<b>52,100,615.5</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	8,314,000.0	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,314,000.0	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(8,314,000.0)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>28,768,885.8</b>	<b>52,100,615.5</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	<i>/Төгрөгөөр/</i>
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	385,738,624.5	724,360.0	(73,534,433.3)	312,928,551.2
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	554,266.7	554,266.7
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>385,738,624.5</b>	<b>724,360.0</b>	<b>(72,980,166.6)</b>	313,482,817.9
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	28,768,885.8	28,768,885.8
C08	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>385,738,624.5</b>	<b>724,360.0</b>	<b>(44,211,280.8)</b>	342,251,703.7
D01	<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>385,738,624.5</b>	<b>724,360.0</b>	<b>(44,211,280.8)</b>	342,251,703.7
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	385,738,624.5	724,360.0	(44,211,280.8)	342,251,703.7
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	52,100,615.5	52,100,615.5
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	385,738,624.5	724,360.0	7,889,334.7	394,352,319.2

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>179,679,587.0</b>	<b>309,008,816.9</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,922,600.0</b>	<b>12,759,000.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,922,600.0	12,759,000.0
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	6,922,600.0	12,759,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,322,600.0	12,759,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.0	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>172,756,987.0</b>	<b>296,249,816.9</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	152,171,287.0	271,439,816.9
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	152,171,287.0	271,439,816.9
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	20,585,700.0	24,810,000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,585,700.0	24,810,000.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>173,408,908.5</b>	<b>299,934,213.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>173,408,908.5</b>	<b>299,934,213.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>151,766,511.8</b>	<b>245,835,807.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	106,576,504.5	173,203,276.0
210101	Үндсэн цалин	75,553,170.5	109,955,771.0
210102	Нэмэгдэл	24,181,658.0	46,650,886.0
210104	Урамшуулал	6,841,676.0	16,596,619.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	12,257,097.0	21,212,590.0
210201	Тэтгэврийн даатгал	8,026,797.0	15,509,692.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,057,500.0	1,425,698.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	845,900.0	712,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	211,600.0	712,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,115,300.0	2,851,600.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,027,753.2	17,832,015.9
210301	Гэрэл, цахилгаан	1,977,753.2	3,132,015.9

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Соёлын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	14,000,000.0	14,400,000.0
210303	Цэвэр, бохир ус	50,000.0	300,000.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,935,000.0</b>	<b>6,766,000.0</b>
210401	Бичиг хэрэг	585,000.0	2,400,000.0
210402	Тээвэр, шатахуун	800,000.0	1,800,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	550,000.0	660,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,000,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.0	906,000.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>1,500,000.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,500,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,535,700.0</b>	<b>4,500,000.0</b>
210604	Урсгал засвар	4,535,700.0	4,500,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>200,000.0</b>	<b>1,300,000.0</b>
210702	Дотоод албан томилолт	200,000.0	1,300,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,134,457.0</b>	<b>17,521,926.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,798,475.0	14,719,100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	864,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.0	1,900,000.0
210807	Газрын төлбөр	155,982.0	38,826.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,100,000.0</b>	<b>2,000,000.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,000.0	2,000,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,642,396.8</b>	<b>54,098,405.5</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,620,150.0</b>	<b>15,094,300.0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,552,800.0	1,539,900.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	11,974,400.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,151,400.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,915,950.0	1,580,000.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>36,526,121.3</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	36,526,121.3
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>22,246.8</b>	<b>2,477,984.1</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,246.8	2,477,984.1
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>6,270,678.5</u></b>	<b><u>9,074,603.5</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>4,140,900.0</b>	<b>11,206,400.0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,140,900.0</b>	<b>11,206,400.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,140,900.0</b>	<b>11,206,400.0</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,140,900.0	11,206,400.0
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(4,140,900.0)</u></b>	<b><u>(11,206,400.0)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>2,129,778.5</b>	<b>(2,131,796.5)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,018.0</b>	<b>2,131,796.5</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,131,796.5</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,131,796.5	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>284,198,900.0</b>	<b>249,804,492.0</b>	<b>34,394,408.0</b>
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>284,198,900.0</b>	<b>249,804,492.0</b>	<b>34,394,408.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>284,198,900.0</b>	<b>249,804,492.0</b>	<b>34,394,408.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>269,104,600.0</b>	<b>234,710,192.0</b>	<b>34,394,408.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>202,159,200.0</b>	<b>173,203,276.0</b>	<b>28,955,924.0</b>
210101	Үндсэн цалин	116,804,100.0	109,955,771.0	6,848,329.0
210102	Нэмэгдэл	68,284,500.0	46,650,886.0	21,633,614.0
210104	Урамшуулал	17,070,600.0	16,596,619.0	473,981.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,269,900.0</b>	<b>21,212,590.0</b>	<b>4,057,310.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,183,500.0	15,509,692.0	1,673,808.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,021,600.0	1,425,698.0	595,902.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,010,800.0	712,800.0	298,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,010,800.0	712,800.0	298,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,043,200.0	2,851,600.0	1,191,600.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,606,000.0</b>	<b>7,766,000.0</b>	<b>840,000.0</b>
210401	Бичиг хэрэг	2,400,000.0	2,400,000.0	-
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.0	1,800,000.0	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.0	660,000.0	840,000.0
210404	Ном, хэвлэл	1,000,000.0	1,000,000.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.0	1,000,000.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	906,000.0	906,000.0	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,500,000.0</b>	<b>1,500,000.0</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.0	1,500,000.0	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,106,400.0</b>	<b>9,106,400.0</b>	<b>-</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,106,400.0	9,106,400.0	-

2107	Томилолт, зочны зардал	1,300,000.0	1,300,000.0	-
210702	Дотоод албан томилолт	1,300,000.0	1,300,000.0	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>19,163,100.0</b>	<b>18,621,926.0</b>	<b>541,174.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,819,100.0	15,819,100.0	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.0	864,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,320,000.0	1,900,000.0	420,000.0
210807	Газрын төлбөр	160,000.0	38,826.0	121,174.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,000,000.0</b>	<b>2,000,000.0</b>	<b>-</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.0	2,000,000.0	-
21	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,094,300.0</b>	<b>15,094,300.0</b>	<b>-</b>
213	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15,094,300.0</b>	<b>15,094,300.0</b>	<b>-</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,539,900.0	1,539,900.0	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,974,400.0	11,974,400.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,580,000.0	1,580,000.0	-
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>284,198,900.0</b>	<b>284,198,816.9</b>	<b>83.1</b>
132001	Улсын төсвөөс санхүүжих	271,439,900.0	271,439,816.9	83.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	12,759,000.0	12,759,000.0	-

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

*Итгэргээгээр!*

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>24,810,000.0</b>	<b>22,332,015.9</b>	<b>2,477,984.1</b>
2	<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>24,810,000.0</b>	<b>22,332,015.9</b>	<b>2,477,984.1</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>24,810,000.0</b>	<b>22,332,015.9</b>	<b>2,477,984.1</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>24,810,000.0</b>	<b>22,332,015.9</b>	<b>2,477,984.1</b>
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,310,000.0</b>	<b>17,832,015.9</b>	<b>2,477,984.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,610,000.0	3,132,015.9	2,477,984.1
210302	Түлш, халаалт	14,400,000.0	14,400,000.0	0.0
210303	Цэвэр, бохир ус	300,000.0	300,000.0	0.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,500,000.0</b>	<b>4,500,000.0</b>	<b>0.0</b>
210604	Урсгал засвар	4,500,000.0	4,500,000.0	0.0
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>24,810,000.0</b>	<b>22,332,015.9</b>	<b>2,477,984.1</b>
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,810,000.0	22,332,015.9	2,477,984.1

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөөнд үйл ажиллагааны орлогыг төлөвлөхгүй байгаа асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 32,552.5 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс 972.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 31,580.0 мянган төгрөгийн зөрчилд 7 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Соёлын төвийн дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт хүргүүлсэн.

##### 5.1 Төлбөрийн акт

Тэтгэвэрт гарсан албан хаагчийн тэтгэмжийг олгохдоо ажилласан жил болон үндсэн цалингийн хэмжээг алдаатай тооцоолж, 972.5 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.2-т “Энэ журмын 1.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн албан хаагчид 2.1-д зааснаар тогтоосон үндсэн цалингийн дунджийг нь төрийн албанд ажилласан нийт жилийн тоотой тэнцэх сарын тоогоор үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн 36 сарын албан тушаалын үндсэн цалингийн дунджаас ихгүй байна.” гэж заасанд нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл дутуу 5,800.0 мянган төгрөгийн ажил гүйлгээ санхүүжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” Гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн бүрдүүлж ажиллах

Илрүүлэлт: Хөрөнгийн тооллогыг хийсэн боловч тооллогын комиссын илтгэх хуудас байхгүй, тооцоо бодсон актгүй, эд хариуцагчдын картад гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тооллогын үр дүнг хэлэлцэж шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх,” гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг өмч хамгаалах комиссын хурлаар хэлэлцүүлж, илтгэх хуудсаар баталгаажуулж байх

**Илрүүлэлт:** Төсвөөс 830.6 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг дагаж мөрдөөгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн зардлын эдийн засгийн ангиллыг баримталж ажиллах

**Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 15 нэр төрлийн 23,449.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын 7 дугаар зүйлийн 7.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр шийдвэрлэх

## 2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Шилэн дансны тайланд төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар оруулж хэвшээгүй, холбогдох тушаал шийдвэрийг хавсралт файлаар оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:” гэж заасан заалтуудтай нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь, иж бүрэн мэдээлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

**Илрүүлэлт:** Хөвсгөл аймгийн Цагаан-үүр сумын Соёлын төв нь ахмадын сан байгуулаагүй, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасанд нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ахмад настны тухай хуульд заасны дагуу Ахмадын сан байгуулж ажиллах.

**Илрүүлэлт:** Нормын хувцасны зардлаас нэг бүр нь 150.0 мянган төгрөгийн өртөг бүхий 10 ширхэг, нийт 1,500.0 мянган төгрөгийн бомбер худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэж заасанд нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж илүү тооцож олгосон	1	972.5	1	972.5				
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	5,800.0					1	5,800.0
Хөрөнгийн тооллогын үр дүнг хэлэлцээгүй	1	-					1	-
Эдийн засгийн ангилал зөрчсөн	1	830.6					1	830.6
0 үлдэгдэлтэй хөрөнгө шийдвэрлээгүй	1	23,449.4					1	23,449.4
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>31,052.5</b>	<b>1</b>	<b>972.5</b>			<b>4</b>	<b>30,080.0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны мэдээлэл дутуу оруулсан	1	0					1	0
Ахмадын сан байгуулаагүй	1	0					1	0
Бомбер худалдан авсан	1	1,500.0					1	1,500.0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,500.0</b>					<b>3</b>	<b>1,500.0</b>